



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 157


Сүхбаатар сум

“Сэлэнгийн брэнд хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Сэлэнгийн брэнд” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хөтөлбөрийн биелэлтийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Ш.БЯМБАА



**“СЭЛЭНГЭ БРЭНД” ХӨТӨЛБӨР**

TTC7446 № 9055363

**Сэлэнгэ аймгийн орон нутгийн онцлог бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016 онд 303.8 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан нь 2015 оны дүнтэй харьцуулахад 81.4 тэрбум.төг буюу 21.1 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлтийн 49.3 хувийг уул уурхайн салбар эзэлж байгаа бол хүнсний үйлдвэрлэл 23.3 хувь, барилгын материал 15.0 хувь бусад салбарт 2.4 хувийг эзэлж байна. 2012-2016 онд дундажаар 479.2 тэрбум.төг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

Үйлдвэрлэл 2011-2013 он дуустал 40,8 хувиар өссөн боловч 2014 оноос 2016 он хүртэл 55,4 хувиар буурсан. 2014 онд нийт аж үйлдвэрлэлийн салбарын 82,9 хувийг уул уурхайн салбар эзэлдэг байсан бол 2014 оноос хойш Редхилл Монголиа, Жамп алт, Бороо гоулд зэрэг уул уурхайн томоохон үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулахаа больсонтой холбогдуулан бусад салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь, нөлөөлөл нэмэгдсэн. 2007 онд 287.47 тэрбум төг үйлдвэрлэлттэй байсан бол 2016 онд 303.90 тэрбум, төг болсон байгаа нь 16.43 тэрбум.төг буюу 5,7 хувиар өссөн дүн харагдаж байна.


Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн салбарыг дараах байдлаар ангилж авч үзэж болохоор байна. Үүнд:

1.Хүнд үйлдвэрлэл /Уул, уурхай, төмрийн хүдэр, нүүрс, алт зэрэг ашигт малтмалын олборлолт, борлуулалт/

2.Боловсруулах үйлдвэрлэл /Хүнсний үйлдвэрлэл, спирт, архи, бүх төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, гурилын үйлдвэрлэл болон талх нарийн боовны үйлдвэрлэлт, борлуулалт/

3.Барилгын материал үйлдвэрлэл /Барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийхэд ашиглагдах материал байх ба цемент, шохой, арматур, тоосго зэрэг материал үйлдвэрлэл, борлуулалт/

4.Бусад үйлдвэрлэл /Модон материал үйлдвэрлэл, дулаан, цахилгаан үйлдвэрлэл зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын үйлдвэрлэл, борлуулалт/





2017 оны байдлаар “Chinggis khan challenge cup 2017”, “Төв, хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах уралдаан, сургалт, урлаг, спортын арга хэмжээ”, “Эрүүл амьдрал экспо”, “Цагаан сар-2017”, “Намрын ногоон өдрүүд” зэрэг Улс, бүс нутгийн, болон орон нутгийн шинжтэй үзэсгэлэн, худалдаанд орон нутгийг төлөөлж оролцож, удаа дараа шагнал хүртдэг эрэлт ихтэй дараах бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэгдэж байна. Үүнд:

1. Үр тариа
2. Төмс, хүнсний ногоо
3. Байгалийн зэрлэг жимс
4. Хмелийн талх
5. Зөгийн гаралтай бүтээгдэхүүн
6. Ургамлын гаралтай цай
7. Загас
8. Ургамлын тос
9. Хоол амтлагч
10. Эсгий эдлэл
11. Годон болон арьсан гутал
12. Нум сум

Аймгийн хэмжээнд орон нутгийн онцлог брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэлээр аймгийн ИТХ-ын 2007 онд Өрхийн аж ахуйг “брэнд” үйлчилгээ болгох тухай 84 дүгээр тогтоол батлагдсан. Түүнчлэн өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2012 оныг “Өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрийг эрчимжүүлэх” жил болгон зарласан, 2013 оны 166 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн”, “Зоорь”, “Жимс, жимсгэнэ”, “Мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх”, “Зөгий” зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байсан.

### **“Сэлэнгийн брэнд” хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Байгалийн баялаг тогтоц, газар тариалан, мал аж ахуй хослон эрхлэх боломж зэрэг нь Сэлэнгэ аймагт орон нутгийн онцлог брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон таатай нөхцлийг бүрдүүлж байна. Бид Монголдоо төдийгүй дэлхийд танигдах баялаг, нөөц сайтай нутаг юм.

Манай үйлдвэрлэгчдийн хувьд Улсын болон бүс нутгийн шинжтэй үзэсгэлэн худалдаанд оролцож удаа дараа шагнал хүртсэн орон нутгийн онцлог шинжтэй, эко, брэнд болохуйц бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэгддэг хэдий ч орон нутгийн зүгээс батламжилж нэгдсэн бодлогоор дэмжих шаардлага байна. Ингэснээр орон нутгийн онцлог бүхий органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжиж, иргэдийн амжиргааны түвшин дээшилж ашиг орлого нэмэгдэх цаашлаад ажлын байр нэмэгдэх, дотоод болон гадаад зах зээлд орон нутгаа сурталчлах нөхцөл бүрдэх юм.

Орон нутгийн үйлдвэрлэгчид адил хэлбэрээр, ижил үе шат, аргачлалаар үйлдвэрлэл явуулах нь элбэг тул нэг нэгнээсээ ялгарах онцлогийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Хэдийгээр зарим нь чанартай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ч ялгарах онцлог байхгүйгээс зах зээлд давамгайл байр суурь эзэлж чаддаггүй.



Хэрэв орон нутагт брэндийг хөгжүүлж чадвал энэ нь зөвхөн өрхийн төдийгүй орон нутгийн эдийн засагт үр өгөөжөө өгч, цаашлаад дэлхийн зах зээлд гарах боломж нээгдэнэ.

Брэнд бүтээнэ гэдэг нэлээдгүй цаг хугацаа шаарддаг учраас одооноос эхлэн орон нутгийн брэндийг бий болгоход үйлдвэрлэгчид анхаарах хэрэгтэй байна. Гэхдээ санхүүжилтын дутмаг байдал, зээлийн хүүгийн өндөр түвшин, ажиллагсдын тооны хүрэлцээ зэргээс шалтгаалан үйл ажиллагаагаа өргөтгөх боломж дутмаг байдал ажиглагддаг.

Соёлын брэндээ таньж, нийтэд танилцуулах нь бүс нутгийн эдийн засаг, нийгмийн бүх талыг дайчлан хөгжүүлэх сайн арга зам юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжсөнөөр соёлын нэрт брэндийг хүмүүст танилцуулах боломжийг авчирсан нь эдийн засаг, нийгмийн бүх талын хөгжлийг ахиулахад ашигтай нөхцөл бүрдүүлж байна.

Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлсэн төдийгүй орон нутгийн онцлогийг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Орон нутгийн онцлог, давуу талыг тусгасан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг тодруулах, тэднийг дэмжиж цаашлаад үйлдвэрлэгч аймаг болох, дотоод болон гадаад зах зээлд орон нутгаа сурталчлах, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд уг хөтөлбөр чиглэх юм.

Тогтоол, шийдвэрийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 17 тоот тогтоолоор батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016-2020 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний “Стратегийн зорилт 2”, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтанд “Сэлэнгийн брэнд” аймгийн хөтөлбөрийг боловсруулж ажиллахаар тусгагдсан.

“Сэлэнгийн брэнд” хөтөлбөрийг боловсруулахдаа брэнд, брэнд дүр, брэнд өнгө төрх гэсэн ойлголтуудыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

-Брэнд - Бусад үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээс ялгарах нэр, лого, загвар, технологи зэргийн цогц, хэрэглэгчдэд хүргэсэн үнэ цэнэ;

-Брэнд дүр - Хэрэглэгчдэд хоногшуулах зорилготой Сэлэнгэ аймгийн онцлогийг илэрхийлсэн дүрслэл;

-Брэнд өнгө төрх - Брэнд дүр, орон нутгийн онцлог бүхий лого, уриа үг зэргийг цогцоор нь авч үзсэн болно.

### **Нэг.”Сэлэнгийн брэнд” хөтөлбөр**

#### **1.1.Хөтөлбөрийн зорилго**

Орон нутгийн онцлог, давуу талыг тусгасан, байгальд ээлтэй, өрсөлдөх чадвартай, шинэ болон уламжлалт технологи бүхий брэнд бүтээгдэхүүнийг бий болгож, сурталчлах замаар эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд уг хөтөлбөрийн зорилго оршино.

#### **1.2.Хөтөлбөрийн зорилт**

1.2.1.Орон нутгийн онцлог бүхий брэнд өнгө төрхийг бий болгож, брэнд бүтээгдэхүүнийг сум, болон аймгийн хэмжээнд тодруулж иргэдэд сурталчлах

1.2.2.Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих;



### **Хоёр.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат**

Хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээр үе шат: 2018-2020 он

Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сайжруулах, шалгаруулалтыг тодорхой болгож олон нийтэд сурталчлах;

Хоёрдугаар үе шат: 2021-2023 он

Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин дотоод, болон гадаад зах зээлд сурталчлан, борлуулалтыг нэмэгдүүлж Олон Улсын зах зээлд нийлүүлэх.

#### **Гурав.Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1.Орон нутгийн онцлог бүхий брэнд өнгө төрхийг бий болгож, брэнд бүтээгдэхүүнийг сум, болон аймгийн хэмжээнд тодруулж иргэдэд сурталчлах;

3.1.1.Орон нутгийн онцлог бүхий брэнд өнгө төрхийг бий болгоно.

-Аймгийн онцлог бүхий брэнд дүрийг бий болгож, уриа үгтэй болох;

-Брэнд дүрийг бүх салбарт холбож ашигладаг болох, сурталчлах;

3.1.2.Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулалтын үйл явцыг тодорхой болгоно.

-Аймгийн Засаг даргын захирамжаар “Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүнийг тодруулах зөвлөл” байгуулах;

-Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүнийг тодруулах зөвлөл нь брэнд бүтээгдэхүүн тодруулах үйл явц, шалгуур үзүүлэлт, баримтлах зарчим зэргийг тусгасан журам боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

-“Сэлэнгийн брэнд”-ээр шалгарсан бүтээгдэхүүнд олгох аймгийн онцлог бүхий брэнд дүрийг агуулсан лого бүтээх;

3.1.3.“Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулах” журмыг иргэдэд сурталчлах

-Үйлдвэрлэгчдэд сургалт зохион байгуулж мэдээ, мэдээллээр хангах;

-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр “Сэлэнгийн брэнд хөтөлбөр”, болон шалгаруулалтын журмын талаар мэдээлэл түгээх;

-Брэнд бүтээгдэхүүн тодруулах явц, санал асуулга, судалгаа зэргийг цаасаар болон интернэт орчинд хийх;

3.1.4.“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүнийг үе шаттайгаар тодорхойлох;

- Сум тус бүр орон нутгийн онцлог бүхий брэнд бүтээгдэхүүнээ тодорхойлох;

- Журмын дагуу сумдын брэнд бүтээгдэхүүн болон үйлдвэрлэгчдийн ирүүлсэн материал дээр үндэслэн хийгдэх шалгаруулалт, иргэдээс авсан саналд тулгуурлах шалгаруулалт гэсэн хоёр үе шаттайгаар аймгийн брэнд бүтээгдэхүүнийг тодруулах;

3.2.Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих;

3.2.1.“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг урамшуулж, бүтээгдэхүүнд таних тэмдэг олгох;

-“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг урамшуулж, бүтээгдэхүүнд гэрчилгээ олгох;

-Тухайн бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэхдээ сав баглаа, боодол дээр “Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүн”-ний лого байршуулна. Мөн “Сэлэнгэ аймаг” гэсэн хаяг, шошго заавал бичигдсэн байх;

3.2.2.“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлана.

-Олон нийтийн сүлжээ, орон нутгийн албан ёсны вэб сайтад үйлдвэрлэгч болон брэнд бүтээгдэхүүний танилцуулга бүхий мэдээллийг байршуулж сурталчлах;

-Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулах сүлжээ цэгт борлуулах эрхийг олгох

-“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүнээр шалгаруулалт тухай бүр өдөрлөг, үзэсгэлэн зохион байгуулах;

-Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цуврал нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэх

3.2.3.“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчд үйл ажиллагааг дэмжин ажиллана.

-Бизнесийн удирдлага, бүтээгдэхүүн хөгжүүлэлт зэрэг сургалтанд тогтмол хамруулж цаашид бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл ажиллагааг дэмжих;

-Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр бизнесийг тогтвортой эрхлэх дадлага, ур чадварыг үйлдвэр эрхлэгчдэд олгох, “Бизнес инкубатор төв” байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулан, хөгжүүлэх;

-Банк, Олон Улсын төсөл хөтөлбөрт хамруулах, зээлжилтэнд давуу талтайгаар оролцох боломжийг бий болгох;

-Барьцаа хөрөнгийн дутагдалтай байгаа “брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулах;

3.2.4.Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулах сүлжээтэй болно.

-“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн борлуулах сүлжээ цэгийг аялал жуулчлалын бүсэд бий болгох;

-“Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот болон бүс нутагт борлуулах цэгүүдийг бий болгох;

-Гадаад харилцаанд тулгуурлан Олон Улсын зах зээлд гаргах талаар санамж бичиг, гэрээ хэлэлцээрт тусгаж ажиллах;

### **Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Аймгийн Засаг даргын захирамжаар “Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүнийг тодруулах зөвлөл” байгуулж “Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүн тодруулах журам”-ын дагуу үйл ажиллагааг удирдага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

А. Орон нутгийн төсөв

Б. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө

В. Олон улсын зээл, тусламж, хандивын хөрөнгө

Г. Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

Д. Бусад эх үүсвэр

### **Зургаа.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн**

“Сэлэнгийн брэнд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийн талаар шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, хөтөлбөр, журам, стандартын хэрэгжилт сайжирсан байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ төрлүүд нэмэгдэж, бүтээгдэхүүний чанар сайжирна



- Ажлын байр шинээр бий болж, ажилгүйдэл багасана.
- Иргэдийн ашиг орлого нэмэгдэж, амжиргааны түвшин сайжирна.
- Сум бүр өөрсдийн “брэнд” бүтээгдэхүүнтэй болсон байна
- Брэнд бүтээгдэхүүний борлуулалтын тоо, төрөл нэмэгдсэн байна.
- Аймаг брэнд бүтээгдэхүүнээрээ дамжуулан Олон Улсын зах зээлд танигдана.
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжиж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирч, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсон байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС